



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

「Багахангай дүүрэгт орон сууцны төсөл
хэрэгжүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн хооронд 2022 онд байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-ний нэгдүгээр зүйлийн 1.2-т заасны дагуу Багахангай дүүргийн иргэдтэй байгуулсан “Түрээсийн орон сууцны өмчлүүлэх гэрээ”-ний эргэн төлөгдөх үндсэн төлбөрөөс хуримтлагдсан хөрөнгөөр орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн гүйцэтгэх захирал (М.Говьсайхан), Багахангай дүүргийн Засаг дарга (А.Сүхболд) нарт тус тус даалгасугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Хот байгуулалт, дэд бүтцийн хороо (Б.Сүхбаатар)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100963